



КООРДИНАТ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг -15081, 5-р хороо
10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө, 92
Утас/Факс: 976-70186131, E-mail: info@coordinate-audit.mn

"БОДЬ ДААТГАЛ" ХХК-ийн
УДИРДЛАГАД

2015-02-25 № 18

тантай _____ -ны № _____ Т

Хараат бус аудиторын дүгнэлт

Бид "БОДЬ ДААТГАЛ" ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ий өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусвар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон мэдэгдэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдал уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар санал дүгнэлтээ илэрхийлэх нь бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь мэргэжлийн ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллахыг, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэлийг дэмжих нотлох зүйлийг аудитын горимоор, сорилын үндсэн дээр шалгадаг. Аудитын горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудитуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор бус, зөвхөн тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимыг тодорхойлох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцтай холбогдох дотоод хяналтыг үнэлдэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

Хийсэн аудит маань бидний санал дүгнэлтийн үндэслэлтэй суурь болно гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний санал дүгнэлтээр энд хавсаргасан "БОДЬ ДААТГАЛ" ХХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ээр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлангуудад тус байгууллагын уг өдрөөрх санхүүгийн байдал хийгээд уг өдрөөр дуусвар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ба түүнд нийцүүлж Монгол Улсын Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн аргачлал, заавар, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

ХҮНДЭТГЭСЭН

КООРДИНАТ АУДИТ ХХК
COORDINATE
AUDIT

П.БАЯРМАА /ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ/